



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 4/2018

Мандалговь

Г Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 133 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Үндэсний сурын спортыг хүүхэд, залууст өвлүүлэн, түүх, соёл, өв уламжлалаараа бахархах үзэл санааг төлөвшүүлэх, сурын харвааг нийтэд сурталчлан хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж, ажилтан албан хаагчдаа үндэсний сурын спортоор хичээллүүлэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

Хоёр. Сум бүр Үндэсний сурын салбар нэгж байгуулан, харваачдыг шинээр бэлтгэх, харвааны хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлж, улсын баяр наадам болон үндэсний уламжлалт үйл ажиллагааг сурын харваатай зохион байгуулж байхыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Үндэсний сурын салбар нэгжийг удирдлага, арга зүйгээр ханган мэдээ, тайланг хагас жил тутамд ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт, тайлан, мэдээг нэгтгэн танилцуулахыг Биеийн тамир, спортын газар /М.Наранбаатар/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /А.Нарантуяа/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

9230570